**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
# ТУШААЛ

2022 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/87 Дуурсах

**Коронавируст халдварын үед сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ сэдэвт анхан шатны эрүүл мэндийн төвийн эмч нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах тухай**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний 2.5 дах, Байгууллагын төлөвлөгөөний 2.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Коронавируст халдварын үед сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ сэдэвт анхан шатны эрүүл мэндийн төвийн эмч нарыг чадавхжуулах сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 15-наас 16-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Сургалтын үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар, зарцуулах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалтанд зарцуулагдах 10.249,880 (арван сая хоёр зуун дөчин есөн мянга найман зуун наян) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА Н.ЭНХЖАРГАЛ

642201349

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
..10...дугаар сарын..17... -ны өдрийн А/87
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

# БАЯНХОНГОР АЙМАГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

## УДИРДАМЖ

“Коронавируст халдварын үед сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ сэдэвт анхан шатны эрүүл мэндийн төвийн эмч нарыг чадавхжуулах сургалт”
зохион байгуулах тухай

**Үндэслэл:**

Баянхонгор аймаг нь 89243 хүн амтай, 20 сумтай. Улаанбаатар хотоос 640км зайтай. Ковид-19 цар тахлын тохиолдол Баянхонгор аймагт 2021 оны 03 сард анх бүртгэгдсэнээс хойш 2022 оны 07 сарын 04-ний өдрийн байдлаар халдварын тохиолдол 23466, нас баралт 40 бүртгэгдсэн байна.

Цаашид Ковид-19 цар тахлын дараагийн дэгдэлт үүсэх магадлалтай тул сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг сайжруулж, яаралтай тусламж үзүүлэх багийг дадлагажуулан сургах шаардлагатай байна.

**Зорилго:**

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг сайжруулж, яаралтай тусламж үзүүүлэх багийг чадавхжуулах.

**Зорилтууд:**

1.Анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах

2.Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын А/814 дүгээр тушаалаар батлагдсан Яаралтай тусламж үзүүлэх үлгэрчилсэн журмын танилцуулга хийх.

3.Эрэмбэлэн ангилалт оновчтой хийх, яаралтай тусламжийн чанар хүртээмжийг сайжруулах

**Хамтран ажиллах байгууллага:** Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль /АШУҮИС/

**Оролцогчид:** Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн их эмч, багийн эмч, сувилагч нар, Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн буюу нийт 75 хүн хамрагдана.

**Төсөв**: 10.249.880 төгрөг

**Үйл ажиллагааны чиглэл:**

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, мэргэжилтнүүд**,** АШУҮИС-ийн багш нар тус аймгийн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч эмнэлгийн ажилтнуудыг хамруулсан танхимын 2 хоногийн сургалт зохион байгуулна.

**Хүлээгдэж буй үр дүн:**

1.Эрүүл мэндийн ажилтнуудын хүн төвтэй цогц эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хандлагын талаар мэдлэг, хандлага сайжирна.

2.Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ /ЭМАШТҮ/ үзүүлэгчдийн эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхи нэмэгдэнэ.

3.Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламжийн чанар хүртээмжийг сайжирна.

-------------------------o0o---------------------

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/87 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ҮЕД СУМ, ӨРХ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭН ШААРДЛАГАТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ СЭДЭВТ АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМЧ НАРЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

| **Хугацаа** | **Үйл ажиллагаа** | **Хариуцах албан тушаалтан** |
|---|---|---|
| 1 | 2 | 3 |
| 2022.10.15-ны өдрийн сургалтын чиглүүлэгч<br>ЭТХ-ийн мэргэжилтэн Г.Лхагва-Очир | | |
| 08.30-09.00 | Бүртгэл | ЭМГ-ын Г.Лхагва-Очир |
| 09.00-09.10 | Нээлт | ЭМГ-ын дарга Н.Энхжаргал |
| 09.10-09.30 | Анхаарах зүйлс | ЭТХ-ийн мэргэжилтэн Г.Лхагва-Очир |
| 09.30-10.00 | Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын А/814 дүгээр тушаалаар батлагдсан Яаралтай тусламж үзүүлэх үлгэрчилсэн журмын танилцуулга хийх. | ЭТХ-ийн мэргэжилтэн Г.Лхагва-Очир |

| Цаг | Сургалтын сэдэв | | Арга | Хугацаа |
|---|---|---|---|---|
| 10.10-10.15 | Багш нарын танилцуулга | | | 5 |
| 10.15-10.30 | Сургалтын өмнөх тест /Олон сонголт бүхий 20 асуулт/ | | Тест | 10 |
| 10.30-10.40 | Сургалтын ерөнхий танилцуулга | | | 10 |
| 10:40 - 10:50 | Зүрх зогссон өвчтөнг таньж илрүүлэх | | Лекц | 10 |
| 10:50 - 11:20 | Цээж шахалт | | Лекц | 30 |
| 11.20-11.25 | Насанд хүрэгчдийн цээж шахалт /үзүүлэх сургалтын видео/ | | Лекц | 5 |
| 11:25 - 11:35 | Хүүхдийн цээж шахалт /үзүүлэх сургалтын видео/ | | Дадлага | 10 |
| | А Баг | Б Баг | | |
| 11:35 - 11:45 | Нялхасын цээж шахалт /үзүүлэх сургалтын видео/ | | Дадлага | 10 |
| | А Баг | Б Баг | | |
| **11.45-12.00 Цайны завсарлага** | | | | |
| 12:00 - 12:10 | Амьсгалын зам чөлөөлөх | | Лекц | 10 |
| 12:10 - 12:30 | Амьсгалуулах | | Лекц | 20 |
| 12:30 - 12:40 | Амнаас аманд /үзүүлэх сургалтын видео/ | | Дадлага | 10 |
| | А Баг | Б Баг | | |
| 12:40 - 12:50 | Амбу маскаар амьсгалуулах /үзүүлэх сургалтын видео/ | | Дадлага | 10 |
| | А Баг | Б Баг | | |
| 12:50 - 13:00 | Хавхлагат хошуувчаар амьсгалуулах /үзүүлэх сургалтын видео/ | | Дадлага | 10 |
| | А Баг | Б Баг | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13.00 - 14.00 | Үдийн хоол | | | 60 | |
| 14:00-14:30 | Багийн тусламж | | | | Лекц |
| 14:30-14:40 | Хүзүү нуруу нугасны гэмтэлтэй өвчтнийг тээвэрлэх | | | Лекц | 10 |
| 14:40 - 14:55 | Мөчдийн хугарлын үед үзүүлэх тусламж | | | Лекц | 10 |
| 14:55 - 15:15 | Хахалт | | | Лекц | 10 |
| 15.15 - 15:30 | Гэмтэлтэй өвчтөн тээвэрлэх үзүүлэх сургалт | | | Лекц | 20 |
| 15:30 - 16:30 | А баг | Б баг | В баг | Дадлага | 30 |
| | Хахалт | Тээвэрлэлт | Боолт | | |

| | | |
|---|---|---|
| 16:30-17:10 | Чиглүүлэгчдийн уулзалт, үнэлгээ | сургалтын баг |
| 2022.10.16-ны өдрийн сургалтын зохицуулагч<br>ЭТХ-ийн мэргэжилтэн Г.Лхагва-Очир | | |
| 08.30-08.50 | Бүртгэл | ЭМГ-ын Г.Лхагва-Очир |
| 09.00-09.30 | Ковид халдварын нөхцөл байдал, нас баралт, томуу, томуу төст өвчний мэдээлэл | ЭМГ-ын Г.Лхагва-Очир |
| 09.30-11.00 | Анхдагч үнэлгээ, амьсгалын зам ба амьсгал, анхдагч үнэлгээний талаарх аман тайлбар зэргийг эргэн ярилцах | сургалтын баг |
| 11.00-11.05 | Сэргээх дасгал | сургалтын баг |
| **11.05-11.15 Цайны завсарлага** | | |
| 11.15-12.00 | Яаралтай тусламжийн үнэлгээ, давтлага | сургалтын баг |
| 12.05-12.55 | Ур чадвар сайжруулах бүлгийн ажил | сургалтын баг |
| 13.00-14.00 | **13.00-14.00 Өдрийн хоол** | |
| 14.00-14.25 | Ур чадвар сайжруулах бүлгийн ажил (үргэлжлэл) | сургалтын баг |
| 14.25-14.35 | Сэргээх дасгал | сургалтын баг |
| 14.35-15.00 | “ЭХО-д суурилсан үнэлгээ | сургалтын баг |
| 15.00-15.30 | Сургалтын эргэн санах ярилцлага | сургалтын баг |
| 15.30-16.10 | Ковид халдварын үеийн хүчилтөрөгчийн хангамж аман асуумж | сургалтын баг |
| 16.10-16.50 | Яаралтай тусламжийн баг томилох тухай үлгэрчилсэн журмыг үндэслэх багаар ажиллах тухай эргэн ярилцах сургалтын талаар аман дасгал хийх | сургалтын баг<br>Г.Лхагва-Очир |
| | Ур чадвар сайжруулах бүлгийн ажил | сургалтын баг |
| **16.50-17.00 Цайны завсарлага** | | |
| 17.00-17.15 | Сэргээх дасгал, Эмнэлзүйн практик | сургалтын баг |
| 17.00-18.00 | Чиглүүлэгчдийн уулзалт, үнэлгээ | сургалтын баг |
| | Оролцогчдын санал бодол, ярилцлага, Үнэлгээний тухай, хаалт | сургалтын баг |

-----------------o0o-----------------